



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр.
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2021.07.09 № 03/1817

танай _____ -ны № _____ -т

Г
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАРТ

Засгийн газрын 2005 оны "Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанад иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны II улирлын тайлан, мэдээг хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

ТӨРИЙН НАРИИН ВИЧИГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ



d:\уухя\2021\ям\a5.docx
08-08-1433

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,
 ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА АШИГТ МАЛТМАЛ,
 ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР БОЛОН ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНД
 ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН
 ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН
 /2021 ОНЫ II УЛИРЛЫН БАЙДЛААР/

ХҮЧНЭГТ №1

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт %
			Шийдвэр-лэж хариу ёгсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хяналтад байгаа	
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	114	106	-	2	6	92.98%
2	Ашигт малтмал, газрын тосны газар	152	128	-	20	4	84.77%
3	Үндэсний геологийн алба	8	7	-	-	1	99%
НИЙТ		274	241	-	22	11	92.25%

2021 ОНЫ II УЛИРАЛД ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
 АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ
 ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ /хэлбэрээр/

ХҮЧНЭГТ №2

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс:				
			Бичгээр	Цахимаар	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	114	114	-	-	-	-
2	Ашигт малтмал, газрын тосны газар	152	152	-	-	-	-
3	Үндэсний геологийн алба	8	8				
НИЙТ		274	274	-	-	-	-

**ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА**

ХЧНЭГТ №3

Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал тоо /нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба	<p>Нийт 274 өргөдлөөс:</p> <ul style="list-style-type: none"> • Хүсэлт – 121 буюу 44.16% • Гомдол - 145 буюу 52.91% • Санал - 8 буюу 0.03% <p>Агуулгаар нь ангилвал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүний нөөцийн асуудлаар – 79 буюу 28.83% 2. Тусламж. дэмжлэг хүссэн – 30 буюу 10.95% 3. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар – 110 буюу 40.15% 4. Сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар – 7 буюу 2.55% 5. Бусад – 48 буюу 17.52% Үүнээс: <ul style="list-style-type: none"> • Алдар цолтон ахмад настны алдар цолны нэмэгдлийн асуудлаар – 17 буюу 6.20% • Салбарын шагналын тэмдэг дахин олгох талаар - 8 буюу 2.92% • “Ти ти жи ви си өү” ХХК-тай байгуулсан гэрээний асуудлаар -5 буюу 1.82% • Лавлагаяа мэдээлэл – 3 буюу 1.09% • Нийгмийн даатгалтай холбоотой асуудлаар - 3 буюу 1.09% • “Таван толгой түүлш” ХХК-тай холбоотой асуудлаар – 2 буюу 0.73% • Маргаан шийдвэрлэх асуудлаар – 2 буюу 0.73% • Салбарын мэргэжлийн индексийн талаар – 1 буюу 0.36% • Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын талаар – 1 буюу 0.36%

Өргөдөл, гомдолын шийдвэрлэлтийг сайжруулах талаар
зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах талаар дараах ажлыг зохион байгуулан ажилласан. Үүнд:

1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн явцын мэдээг Сайдын шуурхай хуралдаанд танилцуулан агентлаг, нэгжийн дарга нарт төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээг түргэн, шуурхай хүргэж ажиллах талаар тодорхой чиглэл өгч, яам, агентлагийн удирдлагуудыг хяналт тавин ажиллахыг үүрэг болгов.

2. Өргөдөл нь тус яамны эрхлэх асуудлын хүрээнд шууд шийдвэрлэх боломжгүй, холбогдох газрын шийдвэр, хариуг хүлээх зэргээс шалтгаалж байгаа тохиолдолд шийдвэрлэлтийн явцыг тэмдэглэх эсхүл иргэн, аж ахуйн нэгжид өргөдлийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг утсаар болон цахимаар мэдээллэж байна.

3. Коронавируст халдварт(Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор гэрээсээ цахимаар ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга үүрэг болгосон. Өгсөн үүргийн дагуу Төрийн захиргааны удирдлагын газрын дарга иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд цаг алдалгүй, шуурхай шийдвэрлэн ажиллахад хяналт тавин ажиллаж байна.

**ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол болон холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэн авч, судалж шийдвэрлэн хуулийн хугацаанд хариу өгч ажиллав.

Тус яаманд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг Сайдын шуурхай хуралдаанд танилцуулан хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд тогтмол хяналт тавин, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын мэдээ, тайланг 14 хоног тутам Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулан ажиллаж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанад 2021 оны II улирлын байдлаар нийт 274 өргөдөл, гомдол албан бичгээр ирсэн байна. Эдгээрээс хариуг шийдвэрлэж албан бичгээр өгсөн 241, хяналтад байгаа 11, хугацаа хэтэрсэн 22 өргөдөл ба шийдвэрлэлт 92,25%-тай байна.

Иргэдээс хандаж ирсэн 274 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар 110 буюу 40.15%, хүний нөөцийн асуудлаар 79 буюу 28.83%, тусламж, дэмжлэг хүссэн 30 буюу 10.95%, алдар цолтон ахмад настны алдар цолны нэмэгдлийн асуудлаар 17 буюу 6.20%, сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар 7 буюу 2.55%, салбарын шагналын тэмдэг дахин олгох асуудлаар 8 буюу 2.92%, “Ти ти жи ви си өү” ХХК-тай байгуулсан гэрээний асуудлаар 5 буюу 1.82%, лавлагаа мэдээлэл хүсэхтэй холбоотой асуудлаар 3 буюу 1.09%, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлттэй холбоотой асуудлаар 3 буюу 1.09%, “Таван толгой түлш” ХХК-тай холбоотой асуудлаар 2 буюу 0.73%, маргаан шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар 2 буюу 0.73%, салбарын мэргэжлийн индексийн талаар 1 буюу 0.36%, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын талаар 1 буюу 0.36% байна.

2021 оны II улирлын байдлаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын тэмдэглэлийг тогтмол хөтөлж хэвшилж үзүүлэлттэй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Сайдын шуурхай хуралдаанаар тус яаманд болон харьяа байгууллага Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албанад иргэдээс хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг танилцуулж сар бүрийн сүүлийн 7 хоногт тайлан, мэдээг Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлж ажиллах талаар чиглэл өгч, чиглэлийн дагуу хяналт тавин ажиллаж байна.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ,
АГЕНТЛАГИЙН ДАРГА, АЛБАН ХААГЧ НАРТ**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Сайдын шуурхай хуралдааны тэмдэглэл:

2021 оны II улирлын байдлаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон харьяа байгууллага Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албанад иргэдээс хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Батбаяр танилцуулав.

Үүнтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд дараах арга хэмжээ авч ажиллахыг яам, агентлагийн удирдлага, албан хаагчдад үүрэг болгов. Үүнд:

1. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг түргэн, шуурхай шийдвэрлэж, хариуг үндэслэлтэй оновчтой байдлаар гаргаж хүргүүлэх;
2. Өргөдөл нь тус яамны эрхлэх асуудлын хүрээнд шууд шийдвэрлэх боломжгүй, холбогдох газрын шийдвэр, хариуг хүлээх зэргээс шалтгаалж байгаа тохиолдолд шийдвэрлэлтийн явцыг тэмдэглэх эсхүл иргэн, аж ахуйн нэгжид өргөдлийн шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээллийг утсаар болон цахимаар мэдээллэх.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ